

НАСНЫ АНГИЛАЛ ТОГТООХ ШАЛГУУР, КИНО ТҮГЭЭХЭД БАРИМТЛАХ ЖУРМЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Эрх зүйн үндэслэл:

Кино урлагийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дах хэсэгт “Монгол Улсад кино бүтээлд насны ангилал тогтоох, түгээх үйл ажиллагаанд мөрдөх Насны ангилал тогтоох шалгуур, кино түгээхэд баримтлах журмыг олон улсын стандартын дагуу Кино урлагийн зөвлөл, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран батална” гэж заасан.

Түүнчлэн Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.16.7 дахь хэсэгт Кино урлагийн зөвлөлд кино түгээлтэд баримтлах насны ангилал тогтоох чиг үүргийг олгосон байна.

Кино урлагийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт кино түгээхэд

21.1.1.бүх насныханд зөвшөөрөх;

21.1.2.13 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх;

21.1.3.18 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх.

гэсэн ангиллаар насны ангилал тогтооно гэж заасан.

Журмын төсөл боловсруулах ажиллагаа: Журмын төсөл боловсруулах ажлын хүрээнд Кино урлагийн зөвлөлийн Ажлын албаны даргын 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн А/10 тоот тушаалаар Монгол улсын нутаг дэвсгэрт **Насны ангилал тогтоох шалгуур, кино түгээхэд баримтлах журмын** төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэгт Кино урлагийн зөвлөлийн гишүүд, Харилцаа холбооны зохицуулах хороо, Жендэрийн үндэсний хороо, Хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын ерөнхий газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Цагдаагийн Ерөнхий газрын урьдчилан сэргийлэх алба, Кино театруудын менежментийн холбоо, “Ю тийм”- ХХК зэрэг холбогдох байгууллагуудын төлөөлөл орсон.

Харилцаа холбооны зохицуулах хорооны дэргэдэх Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих Орон тооны бус зөвлөлийн 2025 оны I улирлын хуралдаанаар журмын төсөл боловсруулах ажлын хэсэгтэй хамтарсан уулзалт зохион байгуулж, өргөн нэвтрүүлэгт мөрдөгдөж байгаа насны ангиллын стандарт болон Кино урлагийг дэмжих тухай хуульд заасан насны ангиллын уялдаа, ялгаа, хэрэгжилтийн асуудлыг хэлэлцэн кино түгээхэд болон өргөн нэвтрүүлгийн салбарт хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах зохицуулалтын уялдааг хангах чиглэлээр гэх мэт асуудлаар журмын төсөл боловсруулахад анхаарах асуудлыг хэлэлцэж, санал солилцсон. Мөн тус зөвлөлийн 2-р хуралдаанаар журмын төслийг танилцуулж, санал авсан болно.

Журмын бүтэц

Журмын төсөл нь 5 бүлэг, 22 зүйл, 4 дэд хэсээс бүрдэх бөгөөд Монгол улсад түгээх кино бүтээлд насны ангилал тогтоох зарчим, шалгуур, кино түгээхдээ тус насны ангиллыг баримтлахтай холбоотой зохицуулалт, хяналт, гомдол маргаан шийдвэрлэх харилцааг зохицуулна.

- **I бүлэг** – Нийтлэг үндэслэл- Энэхүү бүлгээр журмын зорилго, эрхзүйн үндэслэл, мөн журмын хамрах хүрээ буюу тус журмыг мөрдөх этгээдийг тодорхойлсон.
- **II бүлэг** – **Насны ангилал тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал.** Кинонд насны ангилал тогтоох шалгуур үзүүлэлтэд хамаарах үндсэн агуулга, үнэлгээний аргачлал, ангилал тогтоох үйл явц, Монгол улсад түгээж байгаа кино, кинонд тогтоосон насны ангиллын талаарх мэдээлэл хүргүүлэх, энэ талаарх бүртгэл үүсгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан.
- **III бүлэг- Кино түгээхэд баримтлах шаардлага.** Монгол Улсын нутаг дэвсгэрт кино бүтээлийг олон нийтэд түгээх үед мөрдөх шаардлага, насны ангиллын тэмдэг тэмдэглэгээг байршуулах шаардлага, киног аудио хэлбэрээр түгээхэд тавигдах шаардлага, кино түгээх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн чиг үүрэг, мөн 18+насны ангилалтай кино сурталчилгаанд хүүхэд хамгаалах үүднээс тавих агуулгын хязгаарлалтыг тодорхойлсон.
- **IV бүлэг - Гомдол хүлээн авах, шийдвэрлэх.** Энэ бүлгээр насны ангилал буруу тогтоогдсон гэж үзсэн тохиолдолд гомдол хүрээн авах, шийдвэрлэх харилцаа тухайлбал мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан хяналт, үзлэг хийх, дүгнэлт гаргах болон киноны насны ангиллыг өөрчлөх эсэх асуудлаар шаардлага, мэдэгдлийг киноны эрх эзэмшигч, түгээлтийн байгууллага, гомдол гаргагч талд хүргүүлэх үйл явцыг зохицуулсан.
- **V бүлэг. Хариуцлага.** Энэхүү бүлгээр киноны эрх эзэмшигч, кино зуучлагч, түгээлтийн байгууллагын үүрэг хариуцлагыг тусгасан. Тухайлбал насны ангиллыг үнэн зөв тогтоох, Кино урлагийн зөвлөлд мэдээллийг цаг тухайд нь хүргүүлэх, насны ангиллын мэдээллийг олон нийтэд ил тод хүргэх, түгээлтэд насны ангиллыг чанд баримтлах зэрэг үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу журмын төсөлд санал авах ажиллагааг эхлүүлж байна.

Та бүхэн саналаа 2025 оны 12-р сарын 26-ны дотор secretariat@filmmongolia.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛ

КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХАМТАРСАН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

“Насны ангилал тогтоох шалгуур,
кино түгээхэд баримтлах журам ” батлах тухай

~~Монгол Улсын~~ Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.16.7, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Кино урлагийн зөвлөл, Харилцаа холбооны зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт кино түгээхэд баримтлах “Насны ангилал тогтоох шалгуур, кино түгээхэд баримтлах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр журмын үйлчлэлд хамаарах иргэн, хуулийн этгээдэд таниулах, мэдээлэл хүргэх, мөрдүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Кино урлагийн зөвлөлийн Ажлын алба /Б.Болормаа/-нд даалгасугай.

КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА: Ч.УНДРАЛ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:
Б.ДАВААЦЭРЭН
Ж.ДЭЛГЭРЖАРГАЛ
Н.СҮНЖИДМАА
Н.ОНОН
Д.ЭНХБОЛД
Г.БАТСУУРЬ
Д.ЦЭНГЭЛ
Э.ЭНХТҮВШИН
Ц.ХҮСЭЛБААТАР
Э.ЭРДЭНЭЧУЛУУН

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА: Г.ЧИНЗОРИГ
А.ЛУВСАН-ОЧИР
Ч.ЗОЛБАЯР
Б.АНХБААТАР
А.ҮЙЛСТӨГӨЛДӨР
Б.БАТЗОРИГ

НАСНЫ АНГИЛАЛ ТОГТООХ ШАЛГУУР, КИНО ТҮГЭЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт түгээх кинонд насны ангилал тогтоох шалгуур үзүүлэлт, тогтоосон насны ангилалыг баримтлан түгээх харилцааг зохицуулахад энэ журмыг баримтлана.

1.2. Энэхүү журам нь Кино урлагийг дэмжих тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нийцсэн байна.

1.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт кино бүтээх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээд, киноны эрх эзэмшигч болон бусад холбогдох этгээд монгол болон гадаад кинонд насны ангилал тогтоож, бүх төрлийн түгээлтийн сувгаар түгээхэд энэ журмыг баримтлана.

Хоёр.Насны ангилал тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал

2.1. Тухайн киноны эрх эзэмшигч насны ангилал тогтоох шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлж, насны ангилалыг тогтооно.

2.2. Насны ангилал тогтоохдоо дараах үндсэн шалгуур үзүүлэлтүүдэд хамаарах агуулгыг авч үзнэ. Үүнд:

2.2.1.Гэмт хэрэг, хууль бус үйлдэл бүхий агуулга;

2.2.2.Хүчирхийлэл болон хүчирхийллийн шинжтэй дүрслэл;

2.2.3.Бэлгийн агуулга ба садар самуун үйлдэл бүхий илэрхийлэл;

2.2.4.Мансууруулах бодис, архи, тамхи хэрэглэх, түүнийг сурталчлах;

2.2.5.Хараалын үг, зохисгүй хэллэг;

2.2.6.Айдас төрүүлэх, сэтгэл зүйд хүчтэй нөлөөлөх дүрслэл.

2.3. Киног журмын Хавсралтад заасан насны ангиллын шалгуур үзүүлэлт бүрээр үнэлж, өгүүлэмж, дүрслэлд харгалзах хамгийн өндөр ангиллаар тогтооно.

2.4. Гадаад киног Монгол Улсад түгээх эрх бүхий кино зуучлагч нь дотоодод мөрдөгдөж буй шалгуур үзүүлэлтийн дагуу агуулгыг нягталж, нийцээгүй тохиолдолд дахин үнэлгээ хийж насны ангиллыг тогтооно.

2.5.Тухайн кинонд тогтоосон насны ангилал, киноны нэр, үргэлжлэх хугацаа, төрөл, киноны эрх эзэмшигчийн мэдээллийг Кино урлагийн зөвлөлийн Ажлын албанд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.6.Кино урлагийн зөвлөлийн Ажлын алба нь насны ангилал тогтоох шалгуур үзүүлэлт, тайлбарыг олон нийтэд нээлттэй байршуулах ба уран бүтээлч тухайн кино аль насны ангилалд хамаарахыг урьдчилан тооцоолж, нийцүүлэх боломжтой байна.

Гурав. Кино түгээхэд баримтлах шаардлага

3.1. Киноны эрх эзэмшигч, кино зуучлагч нь насны ангилалын тухай мэдэгдэлийг Кино урлагийн зөвлөлийн Ажлын албанд илгээж, төрөлжсөн мэдээллийн санд бүртгүүлнэ.

3.2.Тухайн киног Монгол Улсын нутаг дэвсгэрт түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд насны ангиллыг харуулсан тэмдэг тэмдэглэгээг заавал байршуулна.

3.3.Кино түгээх, кино сурталчилгааны видео дүрс, зурагт хуудсыг олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгсэлээр дамжуулахад насны ангиллын тэмдэглэгээг харааны тусгай хэрэгсэл ашиглахгүйгээр харагдахуйц байдлаар байршуулна. Үүнд:

3.3.1.Кино театрын дэлгэцийн өргөний зургааны нэгтэй тэнцэх хэмжээтэйгээр байрлуулах;

3.3.2.Үзвэрийн өмнө 3-5 секунд дэлгэцэд харуулах;

3.3.3.Сурталчилгааны видео дүрсний эхэнд эсхүл төгсгөлд 1-2 секунд харуулах;

3.3.4.Зурагт хуудасны аль нэг буланд 15 миллиметрээс доошгүй өндөртэй, бусад төрлийн сурталчилгааны материалын 8–10 хувьтай тэнцэх хэмжээтэйгээр байрлуулах;

3.4.Үндсэн шалгуур үзүүлэлтээс тухайн кинонд хамгийн их гарах үзүүлэлтийн мэдээллийг насны ангилалын тоон тэмдэглэгээний хажууд бичгээр харуулна.

3.5.Киног түгээхдээ кинонд тогтоосон насны ангилалыг баримталж, тэмдэг тэмдэглэгээ байршсан эсэхэд кино түгээх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээд хяналт тавина.

Дөрөв.Гомдол хүлээн авах, шийдвэрлэх

4.1. Кино түгээлтийн аливаа сувгаар түгээгдэж буй киноны насны ангилал тохиромжгүй гэж үзвэл иргэн, хуулийн этгээд Кино урлагийн зөвлөлд гомдол, мэдээлэл хүргүүлнэ.

4.2. Гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор тус кинонд хяналтын үзлэг хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд тухайн гомдол, мэдээлэлд тусгасан асуудалтай холбоотой мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан сондгой тооны бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулна.

4.3. Гомдлын дагуу хийгдсэн шалгалтын үр дүнг Кино урлагийн зөвлөл баталгаажуулж, киноны насны ангиллыг шинэчлэн тогтоох шаардлага хүргүүлэх эсвэл хэвээр үлдээх эсэх шийдвэрийг тухайн киноны эрх эзэмшигч болон түгээлтийн байгууллагад хүргүүлнэ.

Тав.Хариуцлага

5.1. Киноны эрх эзэмшигч, кино зуучлагч нь насны ангиллыг үнэн зөв тогтоох, холбогдох мэдэгдлийг хүргүүлэх, насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээг шаардлагын дагуу байршуулж, түгээлтэд гаргахад баримтлах мөн насны ангиллын мэдээллийг олон нийтэд ил тод хүргэх үүргийг хүлээнэ.

5.2. Кино түгээх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээд киноны насны ангилалд хамаарах үзэгчдэд тасалбар, үзвэрийн эрхийг борлуулах, шаардлагатай тохиолдолд хувийн мэдээллийг шалгах үүргийг хүлээнэ.

НАСНЫ АНГИЛАЛ ТОГТООХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮСНЭГТ

№	Үндсэн шалгуур	Шалгуурт хамаарах агуулга	Бүх насныханд (0+)	13+		18+	
				Дүрслэгдэх байдал	Анхаарах зүйлс	Дүрслэгдэх байдал	Анхаарах зүйлс
1	Гэмт хэрэг, хууль бус үйлдэл	Гэмт хэрэг: Хүнд, хөнгөн бүх төрлийн гэмт хэрэг	Хүүхэд дуурайх эрсдэл бүхий үйлдэл тусгахгүй.	Гэмт хэрэг, хууль бус үйлдлийг уран сайханжуулж (амьдралын бодит үйл явдал, дүр, орчныг уран сэтгэмж, гоо зүйтэйгээр найруулан илэрхийлэх) дүрсэлсэн бол; Кино зохиолын өгүүлэмж нь гэмт хэрэг, хууль бус үйлдлийг дүрслэхийн хамт, түүний сөрөг үр дагавар тодорхой дүрслэгдсэн, хууль ёсны хариуцлага, шударга ёсны илэрхийлэлтэй хосолсон байх шаардлагатай.	Өсвөр насны хүүхдийн сэтгэхүйд цочирдол өгөхүйц, хэт хүчтэй дүрслэл, цус, бие махбодид гэмтэл учруулж буй хэсгийг хязгаарлана. Аиваа гэмт үйлдлийг сурталчлах, зөвтгөх, үлгэр дуурайл болгохуйц байдлаар дүрслэхгүй.	Хүнд гэмт хэрэг (хар тамхины наймаа, аллага, хорлон сүйтгэх ажиллагаа, хүн худалдаалах, авлигын гэмт хэрэг гэх мэт)-ийн үйлдлийг бодитой, нарийвчлан хүчирхийлэл агуулсан байдлаар дүрслэн үзүүлсэн бол;	Гэмт хэргийн үйлдлийг зөвтгөх, үзэгчдийг гэмт үйлдэлд өдөөн турхирах, сайн үлгэр дуурайл болгох утга агуулаагүй байх; Дэлгэцийн бүтээлийн дүрслэн үзүүлэх гоо зүйг баримтлах;
		Ялгаварлан гадуурхалт: Тухайн кинонд арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа, нийгмийн	Ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрийг дүрслээгүй, ялгаварласан агуулга агуулагдахгүй.	Ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэр (доромж үг, үйлдэл гэх мэт)-ийн илэрхийлэлийг богино хугацаанд, киноны сэдвийн	Энэ ангилалд зөвшөөрөгдсөн дүрслэл нь өсвөр үеийнхний насны онцлогт нийцэхгүй, ойлгоход хүнд, сэтгэлзүйн дарамт	Ялгаварлан гадуурхалтын аливаа үйлдлийг тодорхой давтамжтай үзүүлсэн, түүнээс үүдэх сөрөг үр	Уран сайхны илэрхийллийн хүрээнд ялгаварлан гадуурхалт, түүний үр нөлөөг чөлөөтэй тусгахдаа

		<i>бүлэг гэх мэт үндэслэлээр бусдыг дорд үзэх, гадуурхах, доромжлох хэлбэрээр илэрч буй агуулга юм.</i>		хүрээнд сургамж (<i>ялгаварлалыг илчилж, жигшихүйц</i>)-тай уур амьсгалтай үзүүлсэн, мөн ялгаварлан гадуурхалтаас үүдэх сөрөг үр дагавар (<i>доромжлол, дээрэлхэлт, амиа хорлолт зэрэг</i>)-ыг дүрсэлсэн бол;	үзүүлж болзошгүй, цочролд оруулахуйц дүрслэл, илэрхийлэлгүй байх; Ялгаварлан гадуурхалтыг зөвтгөсөн, сурталчилсан аливаа агуулгагүй байх;	дагаварыг нарийвчлан дүрслэсэн бол;	дэлгэцийн бүтээлийн дүрслэн үзүүлэх гоо зүйг баримтлах; Ялгаварлан гадуурхалтыг зөвтгөсөн, сурталчилсан аливаа агуулгагүй байх;
2	Хүчирхийлэл	Хүчирхийлэл: <i>Биеэр үйлдэх аливаа хүчирхийлэл болон хүчирхийлэлийн бүхий л төрлүүд (сэтгэл санаа, гэр бүлийн, эрх чөлөө, эдийн засгийн, нэр төр, үл хайхрах, цахим хүчирхийлэл гэх мэт)</i>	Бодит бус, тоглоомын шинжтэй, сэтгэл зүйд хортой нөлөөгүй байх.	Дайн байлдаан, тулаан тэмцэлдээн (<i>зодолдох, буудалцах гэх мэт</i>), аливаа харгис үйлдэл зэрэг хүчирхийлэлийн дүр дүрслэл, үүнээс үүдэх нөхцөл байдал (<i>цус, бие махбодын гэмтэл гэх мэт зураглал</i>) нь өсвөр насны хүүхдэд цочрол төрүүлэхгүй байдлаар дүрслэгдсэн байна.	Хүчирхийллийг сурталчилсан, өдөөн турхирсан, баатарлаг амжилтад хүрэх арга хэрэгсэл болгон харуулахгүй байх;	Хүчирхийллийг аливаа хэлбэрийг илүү тод томруун , бодит дүрслэх боловч дүрслэн үзүүлэх уран сайхны хэм хэмжээ, гоо зүйг баримтлах;	Хэт харгис хүчирхийлэл нь уран сайхны санаа эсхүл нийгмийн асуудлыг хөндсөн, шүүмжлэл агуулсан, урьдчилан сэргийлэх зорилготой агуулгад хязгаартайгаар хамаарна.
		Бэлгийн хүчирхийлэл: <i>Зөвшөөрөлгүйгээр бэлгийн үйлдэл хийх, тулгах, дарамтлах, эсвэл бэлгийн</i>	Бэлгийн хүчирхийлэлийн шинжтэй үйлдлийг огт тусгахгүй.	Бэлгийн хүчирхийлэлийн үйлдлийг шууд илэрхийлэлгүй адилтгал, зүйрлэлийн дүрслэл,	Бэлгийн хүчирхийлэлийн үйлдлийг илэрхийлсэн дүрслэл нь өсвөр насны хүүхдэд цочрол	Бэлгийн хүчирхийллийн аливаа хэлбэрийн бодит үйлдлийг зохистой хязгаартай	Ёс суртахуунгүй хүчирхийлэл, садар самуун үйлдлийг зөвтгөсөн буюу үзэгчийг төөрөгдүүлж

		харьцаанд оруулах оролдлого хийх ;		өгүүлэмжээр илэрхийлэх;	төрүүлэхүйц бус, энэхүү үйлдлийг эсэргүүцсэн агуулгаар, зөвхөн сургамж болгох зорилгоор өгүүлэмжид орсон байна. Энэхүү сэдвийг маш мэдрэмжтэй, хариуцлагатай байдлаар дүрслэх шаардлагатай.	дүрслэн үзүүлэх бөгөөд садар самуун шинж байдлын дүрслэлийг агуулахгүй.	болзошгүй байдлаар дүрслэхгүй байх;
		Амиа хорлолт: <i>Өөртөө чиглэсэн хүчирхийлэл</i>	Амиа хорлолтын аливаа хэлбэрийн үйлдлийг огт тусгахгүй.	Амиа хорлолтын үйлдлийг дэлгэрэнгүй үзүүлэхгүй, товч байдлаар дүрслэн үзүүлэх эсвэл адилтгал, зүйрлэл ашиглан дүрслэх;	Амиа хорлолтын үйлдлийг өсвөр насны хүүхдэд цочрол төрүүлэхүйц бус, сэтгэлзүйн хувьд өдөөлт өгөхгүй, харин сэтгэлзүйн дэмжлэгийн ач холбогдлыг ойлгуулах, ухаарал, мэдлэг өгөх зорилгоор дүрслэгдсэн байна. Энэхүү сэдвийг маш мэдрэмжтэй, хариуцлагатай байдлаар дүрслэх шаардлагатай.	Амиа хорлолтын үйлдлийг бодит байдлаар дүрслэж болох боловч үзэгчид хэт цочирол өгөхүйц хурц, аймшигтай дүр зураглал үзүүлэхгүй. Мөн уг үйлдлийг хийх учир шалтгаан, сөрөг үр нөлөөг тусгавал зохино.	Уран сайхны санаа, нийгмийн асуудлыг хөндөх зорилгоор энэхүү үйлдлийг дүрслэх боловч нарийвчилсан арга ажиллагааг үзүүлэхгүй, өдөөн турхирах, уянгын, эсвэл зөвтгөсөн хэлбэртэй байж болохгүй.
3	Бэлгийн агуулга ба садар самуун	Романтик харилцаа ба бэлгийн харилцаа	Романтик харилцааны зөөлөн илэрхийлэл	Романтик харилцааны зөөлөн илэрхийлэл дүрслэгдэж болох	Дүрслэгдсэн бэлгийн харилцааны аливаа дүрслэл нь	Бэлгийн харилцааны аливаа дүрслэл нь ил тод	Бэлгийн харилцааг ил тод, нарийвчилсан

			(үнсэх, тэврэх гэх мэт)-ийг үзүүлэх, бэлгийн харилцааны аливаа дүрслэлийг хориглох	бөгөөд бэлгийн харилцааны үйлдлийн тодорхой байдал, хөдөлгөөний нарийвчилсан дүрслэл, дуу авиа, өдөөн хатгасан яриа, сэтгэл хөдлөлийг хэт илэрхийлсэн байдалгүй, товч, далд байдлаар дүрслэнэ. Мөн бэлгийн харилцаа, эротик, садар самуун үйлдлийг илэрхийлсэн биеийн хөдөлгөөний хэлэмжийг үзүүлэхгүй.	өсвөр насны хүүхдэд бэлгийн боловсролын зөв ойлголт төрүүлэхүйц байна.	тодорхой дүрслэлтэй байж болох боловч уран сайхны хэв маягаар дэлгэцийн бүтээлийн дүрслэн үзүүлэх гоо зүйг баримтлан дүрслэх бөгөөд садар самуун шинжтэй илэрхийлэл байж болохгүй.	хөдөлгөөнтэй, хүчтэй сэтгэл хөдлөл, дуу авиа дагалдсан байдлаар дүрслэсэн бол өргөн нэвтрүүлэгийн сувгаар түгээхэд тохиромжгүй.
		Хүний нүцгэн биеийг харуулах	Бэлгийн утгагүй, хүний энгийн нүцгэн төрхийг хязгаарлагдмал хэмжээнд дүрслэх	Нүцгэн байдал нь цухас, тодорхой бус, бэлгийн утга агуулаагүй, богино хугацаатай, нөхцөл байдлын хүрээнд дүрслэгдсэн байна. Бие махбодыг үзүүлсэн тохиолдолд бэлэг эрхтэн, хөх, биеийн доод хэсгийг илт, тодоор харуулахгүй.	Энэхүү дүрслэл нь өсвөр насны хүүхдэд буруу ойлголт, сэдэл, өдөөлт төрүүлэхгүй байдлаар дүрслэх шаардлагатай.	Нүцгэн бие ил тод дүрслэгдэх бөгөөд бэлгийн агуулгатай байж болно. Гэвч садар самуун шинжтэй илэрхийлэл байж болохгүй.	Энэхүү дүрслэл нь Кино театр, эсхүл Видео сан, төлбөртэй сувгуудад зөвшөөрөгдөх боловч өргөн нэвтрүүлэгийн сувгаар нүцгэн байдлыг цухас, тодорхой бус, бэлгийн утгагүй, нөхцөл байдлаас шалтгаалсан байдлаар

							хязгаарлагдмал хүрээнд зөвшөөрнө. Бэлгийн эрхтэн, хөх, биеийн доод хэсгийг ил тод харуулахгүй.
		Биеэ үнэлэх үйлдлийг харуулах	Биеэ үнэлэх үйлдлийг дүрслэн үзүүлэхгүй.	Биеэ үнэлэлтийг нийгэмд байх сөрөг үзэгдэл бөгөөд хувь хүний хөгжил, нийгмийн харилцаанд хор уршигтай гэсэн агуулгаар хэт задгай зураглал, гоёчилсон байдалгүй дүрслэх;	Энэхүү дүрслэл нь өсвөр насны хүүхдэд буруу ойлголт, сэдэл, өдөөлт төрүүлэхгүй байдлаар дүрслэх шаардлагатай.	Биеэ үнэлэлтийн үйлдлийг садар самуун хэв шинжгүй, амьдралын бодит үнэн дүр төрхөд нийцүүлэн, зохистой байдлаар дүрслэх;	Энэхүү сэдэв нь нийгмийн эмзэг, олон талт асуудалтай тулгардаг тул хүний эрхийг дээдэлсэн байдалд анхаарах шаардлагатай.
4	Мансууруулах бодис, архи, тамхи	Архи, тамхины хэрэглээг дүрслэх харуулах	Тамхины хэрэглээг хязгаартай, хөнгөн хэлбэрээр үйл явдлын орчны нэгэн хэсэг, соёлын элемент (<i>гаансаар тамхи татах</i>) байдлаар хальт дүрслэхийг зөвшөөрөх;	Зохиолын учир холбогдлын дагуу, дүрийн зан байдлыг үзүүлэх зайлшгүй шаардлагатай бол архи, тамхийг гоёчилсон хэв маяггүй үзүүлэх эсвэл архи, тамхины сөрөг үр дагавар (<i>архи, тамхины нөлөөгөөр эрүүл мэнд муудах, алдаа гаргах гэх мэт</i>)-ыг дүрслэнэ. Ингэхдээ насанд хүрээгүй хүүхэд архи, тамхи хэрэглэж байгаа	Дүрүүд архи, тамхийг хэрэглэх нь тэднийг "эр зоригтой", "загварлаг" гэх мэтээр харагдуулж өсвөр насны хүүхдэд даган дуурайх сэдэл төрүүлэхүйц байж болохгүй. Эдгээр нь сөрөг үйлдэл гэдгийг ухуулсан агуулгатай байвал зохино.	Архи, тамхины хэрэглээг бодитоор дүрслэх боломжтой. Ингэхдээ сурталчилгааны шинжийг агуулахгүй. Мөн эдгээр хорт зуршилд донтох сэтгэлзүйн үйл явц, бусадтай харилцах харилцаанд нөлөөлөх сөрөг үр дагаварыг ч бодитоор	Энэ ангилалд архи, тамхины хэрэглээг илүү уян хатан дүрслэх ч гэсэн ёс зүй, уран сайхны шаардлага, нийгмийн хариуцлага гэсэн хүчин зүйлсийг зайлшгүй анхаарах хэрэгтэй.

				байдлаар дүрслэхгүй.		дүрслэх нь зохимжтой.	
		Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, үр нөлөөг харуулах	Ямар ч хэлбэрээр мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тусгахыг хориглоно.	Боловсрол олгох ,нийгмийн зөв хандлагыг төлөвшүүлэх, урьдчилан сэргийлэх зорилготой бүтээлд хязгаарлагдмал хэмжээнд зөвшөөрөгдөнө. Үүнд: • Эрүүл мэнд, нийгэмд үзүүлэх хор уршгийг тайлбарласан • Хууль эрхзүйн зохицуулалт, хориглолт, үр дагаварын талаарх мэдээлэл өгсөн • Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тусламж, үйлчилгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээ, тайлбар,баримтат контент	Агуулгын үзэл баримтлал чухал: • Сөрөг үр дагаврыг ойлгуулах, сургамж өгөх зорилготой дүрслэл байх. • Хэрэглээнээс татгалзах урам зориг,тусламж авах боломж, ээрэг үлгэр дуурайлыг харуулсан бол зохимжтойд тооцно.	Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний нээлттэй, тод томруун дүрслэл байж болно. Харин хуулиар хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан агуулгатай, хууль бус хэрэглээг өдөөсөн, заасан, шинжтэй байж болохгүй; Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний донтолт, үр	Мансууруулах бодис, архи, тамхины хэрэглээг харуулсан уран сайхны бүтээл нь нийгмийн асуудлыг хөндсөн, ёс суртахууны хэм хэмжээг баримталсан, үзэгчдэд зөв үнэт зүйл, хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн агуулгатай байна. Уг хэрэглээтэй холбоотой хэт задгай, зааварчилгаа шиг дүрслэл, агуулга хориглоно.

				Уран сайхны бүтээлд зөвшөөрөгдөх нөхцөл: • Ерөнхий үзэл санаа хэрэглээний сөрөг үр дагаврыг харуулах • Мансууруулах бодис хэрэглэж буй дүр нь сөрөг дүр байх ба, агуулга нь уг үйлдлийг шүүмжилсэн байр суурь илэрхийлсэн байх • Агуулга нь хэрэглээг өдөөх, сурталчлах шинжгүй, зэрэгээр үзүүлэх шинжгүй байх Дүрслэл болон илэрхийлэлд тавих хязгаар. Үүнд: • Хэрэглээний үйл явц, нэр төрлийг дэлгэрэнгүй, давтамжтай харуулахгүй. • Уянгын, баатарлаг, хошин өнгө аястайгаар дүрсэлж, сөрөг зан		дагаврыг уран сайхны илэрхийлэл, гоо зүйг баримтлан дүрслэх;	
--	--	--	--	--	--	---	--

				үйлийг эерэгээр харагдуулахгүй.			
5	Хараалын үг, хэллэг	Дүрийн хэл ярианд илрэх доромж үг, хэллэг	Ердийн доромж үгийг хязгаарлагдмал байдлаар агуулж болно.	Дүрийн хувийн, онцгой зан байдлыг харуулах үүднээс ердийн доромж үгийг цоон давталттай хэрэглэх; Энэхүү үг хэллэг нь нэн бүдүүлэг, эрээ цээргүй зохисгүй үг хэллэг (<i>бэлгийн утгатай, улс төр, шашин, арьс өнгө, хүйсийн талаар бүдүүлэг үг хэллэг биш байх</i>) байж болохгүй	Энэхүү үг, хэллэг нь өсвөр үеийнхний насны онцлогт нийцэхгүй, ойлгоход хүнд, даган дуурайх сэдлийг төрүүлэхгүй байх;	Хараалын үг, бүдүүлэг хэллэгийн хэрэглээ онцгой хязгааргүй боловч давтамж нь хязгаартай, зохиолын агуулга, дүрийн зан байдалтай нийцэж байх ёстой.	Нийтийн ярианы соёлыг хүндэтгэж, бүдүүлэг хэл яриаг сурталчлах бус дүрийн зан байдал, сэтгэлзүйн онцлогтой уялдуулан учир шалтгаантай боловсруулсан байна.
6	Айдас төрүүлэх, сэтгэл зүйд нөлөөлөх дүрслэл	Хүний сэтгэл зүйн уналт: <i>солиорол, сэтгэцийн эмгэг, хардалт, ганцаардал гэх мэт</i>	Ерөнхийлөн дүрслэх	Хүний сэтгэл зүйн эмзэг байдал, сэтгэцийн эмгэгийг товч, шууд бус байдлаар дурдсан байж болох ч, уг агуулга нь нарийн дүрслэлгүй, сэтгэлзүйн хувьд өдөөлт өгөхгүй, зөвтгөсөн шинжгүй дүрслэл байна.	Эдгээр дүрслэл нь хэт айдас төрүүлэх, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх дүрслэл байж болохгүй.	Хүний сэтгэл зүйн эмзэг байдал, сэтгэцийн эмгэгийг ил тод, нээлттэй дүрслэхдээ дүрслэлийн уран арга, уран сайхны илэрхийлэлийг баримтлан дүрслэх;	Үзэгчийн дотоод сэтгэл зүйд хэт айдас, түгшүүр, таагүй байдал төрүүлэхээс зайлсхийх
		Хүнд аймшигт төрүүлэхүйц дүр зураглал: <i>нийтийг хамарсан золгүй осол, Хүний бие өөрчлөгдөх, задрах, гаж буруу болох,</i>	Ерөнхийлөн дүрслэх	Зохиолын үйл явдлын орчны аймшигтай, аюултай, учир битүүлэг зэрэг нөхцөл байдлын уур амьсгалыг	Өсвөр насны хүүхдийн сэтгэхүйд цочирдол өгөхүйц, хэт хүчтэй дүрслэлийг хязгаарлана.	Аймшигт дүр зураг, аюулт нөхцөл байдлыг чөлөөтэй дүрслэх боловч дэлгэцийн бүтээлийн	Үзэгчийн дотоод сэтгэл зүйд хэт айдас, түгшүүр, таагүй байдал төрүүлэхээс зайлсхийх

		Реал ба сюрреал дүрслэл хосолсон, ойлгомжгүй, нууцлаг, айдас төрүүлэх дүрслэл, байгалийн гамшиг, араатан амьтны дайралт гэх мэт		үзэгчид мэдрүүлэх зорилгоор товч, хэт хүнд дүрслэлгүй дүрслэн үзүүлэх;		дүрслэн үзүүлэх гоо зүйг баримтлах;	
--	--	--	--	---	--	---	--